# ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ХУРЛЫН ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 06 дугаар сарын 13 №09 Улаанбаатар хот

Хөтөлбөрийн ерөнхий хорооны хурал 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн 1-203 тоот өрөөнд 10:15 цагаас 83 хувийн ирцтэй эхэлж, ХЕХ-ны нарийн бичгийн дарга М.Эрдэнэтуяа удирдан явуулав.

**Хуралд**: Дарга Н.Эрдэнэхүү, нарийн бичгийн дарга М.Эрдэнэтуяа, гишүүн Д.Оюунцэцэг, М.Оюунчимэг, Б.Аюурзана, Б.Оюунтунгалаг, Д.Биндиряа, Л.Амартүвшин, Б.Мөнхцэнгэл, А.Болормаа, Я.Батцэцэг, Ш.Цоож, М.Дэлгэрмаа, Ц.Энхтуул, Г.Батцэцэг, Д.Ариунболор, Г.Ариунтөгс нар оролцов.

**Хэлэлцсэн асуудал:**

1. Дархан-Уул аймаг дахь технологийн сургуулийн сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явц
   - СЧА-ны дарга Н.Одонтуяа
2. Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн сургуулийн сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явц
   - Сургалтын албаны дарга Д.Болор-Эрдэнэ
3. Сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийсэн багийн ажлын үр дүн, дүгнэлт
   - ХЕХ-ны гишүүн Я.Батцэцэг
4. Сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийсэн багийн ажлын үр дүн, дүгнэлт
   - ХЕХ-ны гишүүн П.Ууганбаяр

## ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

| № | Хэлэлцүүлсэн асуудал | Санал, зөвлөмж | ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: |
|---|---|---|---|
| 1. | Дархан-Уул аймаг дахь технологийн сургуулийн сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явцын танилцуулга | - Хөтөлбөрийн боловсруулалт хангалтгүй байгаад анхаарч дахин ажиллах шаардлагатай (хөтөлбөрийн үзэл баримтлал хэсгийг боловсруулаагүй, зорилтуудын хоорондын хамаарлыг үгээр тодорхойлж бичих, сонгон судлах хичээл дутуу);<br>- Хөтөлбөрийн элсэлтийн бодлогын төлөвлөлтийг сайжруулах;<br>- Хичээлээр олгох ур чадварууд хөтөлбөрийн суралцахуйн үр дүнтэй хэрхэн яаж холбогдож байгааг зөв тодорхойлох;<br>- Хичээлийн хөтөлбөрийн агуулгыг дахин нягтлах (сурах бичгийг шинэчлэх, агуулга шинэчлээгүй, хичээлийн кодлолтын зарчим баримтлах, багц цагийн задаргааг нягтлах);<br>- Хичээлийн хөтөлбөрүүдийг ижил нэг загварт оруулах (ШУТИС-д мөрдөх жишиг загварын хүрээнд);<br>- Техникийн болон механик алдаа нилээд байгааг засах (хичээл хоорондын уялдааг буруу төлөвлөсөн, үг үсгийн алдаа, санал болгох төлөвлөгөөнд сонгон кредит дутуу төлөвлөсөн, найруулгын алдаатай, сургалтын хөтөлбөр боловсруулах жишиг загварын бичиглэлийг шууд хуулсан байгааг анхаарах);<br>- STEEP, SWOT шинжилгээний үр дүнг дүгнэлт хэлбэрээр тайлбарлан бичиж оруулах; | ДаТС-ийн бакалаврын 20 хөтөлбөрийг ХЕХ-ны гишүүдийн саналыг тусган, сайжруулалт хийн, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлд эцэслэн хэлэлцүүлэхийг (95%) дэмжлээ. |
| 2. | Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явцын танилцуулга | - Хөтөлбөрийн боловсруулалт хангалтгүй байгаад анхаарч дахин ажиллах шаардлагатай (зорилго, зорилт алдаатай, сонгон судлах хичээл дутуу);<br>- Цөм хөтөлбөрийн шаардлагад нийцүүлэн дахин төлөвлөх;<br>- STEEP, SWOT шинжилгээний дутуу;<br>- Ижил төстэй хөтөлбөртэй харьцуулсан судалгаа хийгээгүй;<br>- Хичээлээр олгох ур чадварууд хөтөлбөрийн суралцахуйн үр дүнтэй хэрхэн яаж холбогдож байгааг зөв тодорхойлох;<br>- Хичээлийн хөтөлбөрийн агуулгыг дахин нягтлах (сурах бичгийг шинэчлэх, агуулга шинэчлээгүй, хичээлийн кодлолтын зарчим баримтлах, багц цагийн задаргааг нягтлах); | ЭЦДС-ийн бакалаврын 11 хөтөлбөрийг ХЕХ-ны гишүүдийн саналыг тусган, сайжруулалт хийн, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлд эцэслэн хэлэлцүүлэхийг (90%) дэмжлээ. |

| | | | |
|---|---|---|---|
| | | - Хичээлийн хөтөлбөрүүдийг ижил нэг загварт оруулах (ШУТИС-д мөрдөх жишиг загварын хүрээнд);<br>- Техникийн болон механик алдаа нилээд байгааг засах (хичээл хоорондын уялдааг буруу төлөвлөсөн, үг үсгийн алдаа, найруулгын алдаатай, сургалтын хөтөлбөр боловсруулах жишиг загварын бичиглэлийг шууд хуулсан байгааг анхаарах); | |
| 3. | Дүгнэлт | • Хөтөлбөр дамжуулан болон 2 сургуульд үндсэн хэлбэрээр хэрэгжүүлж буй сургуулийн салбар, тэнхим хамтын ажиллагаатай, санаачлагатай ажиллах (Орон нутгийн бүрэлдэхүүн, харьяа сургуулиудад бакалаврын сургалтын хөтөлбөр боловсруулах үйл ажиллагааны удирдамж).<br>• СХБА хөтөлбөр дамжуулалтын үйл ажиллагааг бодлогоор дэмжин ажиллаж, цаашид дамжуулан хэрэгжүүлэх хөтөлбөрийн талаар бодлогын баримт боловсруулан зохицуулалт хийж ажиллах;<br>• Хөтөлбөрийн боловсруулалтад орон нутгийн сургууль идэвхи санаачлагатай ажиллах, хамтын ажиллагааг сайжруулах<br>• Хөтөлбөрийн үндсэн хариуцагч салбар дэмжиж ажиллах (БАС, БуХС, ГУУС, МехТС, МХТС, ҮТС, ЭХС)<br>• Багшлах боловсон хүчнийг чадавхижуулах талаар цахим сургалтын арга хэлбэрүүдийг сонгох<br>• Орон нутгийн болон улаанбаатар хотын багшийг урьж ажиллуулан туршлага солилцох үйл ажиллагаа зохион байгуулах | |

Танилцсан: Н.Эрдэнэхүү
/ХЕХ-ны дарга/

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: М.Эрдэнэтуяа
/ХЕХ-ны нарийн бичгийн дарга/